

5

МОНГОЛ-ЯПОНЫ ХУДАЛДАА ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

Э.Гүргэмжав

Удиртгал

Даяаршил эрчимтэй явагдаж байгаа өнөө үед Монгол улсын эдийн засагт гадаад орчиноос үзүүлэх нөлөөлөл улам нэмэгдэж байна. Монгол улс өндөр хөгжилтэй орнуудтай худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой юм. Монгол Японы худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа 1990 оноос шинэ шатанд гарч өргөжин хөгжиж байна. Ялангуяа Япон улсаас манай улсад оруулж байгаа хөрөнгө оруулалт, зээл тусламж нэмэгдэж зохих үр өгөөж өгсөөр байгаа юм.

Ийм учраас Монгол Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн судлах шаардлага ач холбогдол өссөн нэмэгдэж байна. Уг өгүүлэлд Монгол японы худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг үечлэн судлаж зарим дүгнэлт өгч санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Нэг. Монгол-Японы худалдаа, эдийн засгийн харилцааны хөгжлийн товч түүх

1959 оны 8-р сарын 12-нд: хоёр орны худалдааг хөгжүүлэх талаар протокол

1960 оноос: БНМАУ-Япон улсын хооронд худалдаа хийж эхэлсэн

1960-аад оны үед: Япон улсаас импортолж байсан бараа, бүтээгдэхүүн - атомшины дугуй, өргөн хэрэглээний бараа хувцас, эмнэлгийн багаж хэрэгсэл, транзистор; БНМАУ-аас Япон улсад экспортолж байсан бараа, бүтээгдэхүүн - арьс, шир, адуу үхрийн хялгас, мод;

1972 онд: БНМАУ-Япон улсын хооронд дипломат харилцааг тогтоосон.

1977 онд: Монгол улс, Япон улсын хооронд эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай засгийн газар хоорондын хэлэлцээр Улаанбаатар хотноо байгуулагджээ.

1978 онд: Ноос ноолуурын “Говь” үйлдвэрийг барих гэрээг байгуулагдсан.
1978-1981 онуудад: Үйлдвэрийг барьж байгуулсан.

Хоёр орны хооронд хийгдсэн бараа гүйлгээ:

1966-1970 онд 4.0 сая ам долларт

1971-1975 онд 5.5 сая ам долларт

1976-1980 онд 6.4 сая ам долларт

1981-1985 онд 31.8 сая ам долларт Япон Монголын эдийн засгийн асуудал эрхэлсэн хорооны гишүүд - Япон улсын 40 гаруй пүүс, компанийн төлөөлөгч 1990- ээд оноос: Монгол оронд өрнөсөн улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн үр нөлөөгөөр хоёр улсын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа шинэ шатанд гарах болсон юм.

Хоёр. Монгол-Японы худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Монгол Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байдлыг гурван чиглэлээр авч үзэж болох юм. Үүнд:

1. Монгол- Японы худалдааны харилцаа
2. Хөрөнгө оруулалт
3. Япон улсаас Монгол улсад оруулж буй зээл тусламж

1. Монгол- Японы худалдаа

1990 онд: Хоёр орны засгийн газар хооронд худалдааны хэлэлцээр байгуулсан.

Хоёр орны худалдааны эргэлт:

1990 онд:

17,4 сая ам.доллар

-Иточү,

-Сумитомо,

-Нишшёо,

-Ивай,

2009 онд

131 сая ам.доллар

-Марубени,

-Комацу,


-Тоёото,

-Мицубиши



Хоёр орны гадаад худалдааны нийт эргэлтийг авч үзвэл тогтвортой өсөлт төдийлөн байхгүй боловч ер нь цаашдаа өсөх ерөнхий хандлага ажиглагдаж байна.

Монгол-Японы гадаад худалдааны нийт эргэлт



Он

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтэд Япон улсын эзлэх хувь хэмжээний өсөлтийг дараах судалгаанаас харж болох юм.

Хүснэгт-1

	1995			1996			1997			1998		
	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт
Нийт бараа	937 196,80			875 195,10			919 818,90			848 447,90		
Япон Улс	140 601,60	15		112 824,60	12,9	80,2	61 115,70	6,6	54,2	68 353,00	8,1	111,8
Экспорт	521 905,50			424 267,10			451 542,70			345 150,30		
Япон Улс	95 340,90	18,27		34 987,80	8,25	36,7	26 441,60	5,86	75,6	9 100,30	2,64	34,4
Импорт	415 291,30			450 927,90			46 827 620			503 297,50		
Япон Улс	45 260,60	10,9		77 836,90	17,26	172	34 674,10	7,4	44,5	59 252,60	11,77	17090

	1999			2000			2001			2002		
	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт
Нийт бараа	966 996,90			1 150 339,00			1 159 229,00			1 214 708,30		
Япон Улс	125 911,40	13	184,2	81 431,30	7,1	64,7	71 700,40	6,2	88,1	49 083,30	4	68,5
Экспорт	454 211,40			535 831,50			521 487,60			523 963,30		
Япон Улс	10 890,70	2,4	119,7	8 107,60	151	74,4	15 715,30	3,01	193,8	6 322,20	1,21	402
Импорт	512 785,40			614 507,50			637 731,40			690 745,00		0
Япон Улс	115 020,70	22,43	94,1	73 323,70	11,93	63,7	55 985,10	8,78	76,4	42 761,10	6,19	76,4

	2003			2004			2005		
	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт	үнийн дүн	хувиар	өсөлт
Нийт бараа	1 416 886,9			1 890 801,40			2 202 349,60		
Япон Улс	71 925,70	5,1	146,5	108 389,10	5,7	150,7	74 690,60	3,4	68,9
Экспорт	615 867,20			869 660,90			1 053 691,20		
Япон Улс	8 509,30	1,38	134,6	33 426,70	3,84	392,8	5 784,10	0,55	17,3
Импорт	80 101 970			1 021 140,50			1 148 658,40		
Япон Улс	63 416,40	7,92	148,3	74 962,40	7,34	118,2	68 906,50	6	91,9

	2006			2007			2008			2009		
	Үнийн дүн	Хувиар	Өсөлт	Үнийн дүн	Хувиар	Өсөлт	Үнийн дүн	Хувиар	Өсөлт	Үнийн дүн	Хувиар	Өсөлт
Нийт бараа	3 028 371,5			21 661 629,2			6 155 097,6			4 033 896,4		
Япон улс	104 741,7	3.5	140.2	155 306,2	0.7	148.3	266 444,9	4.3	171.6	101 566,1	2.5	38.1
Экспорт	1 542 761,7			1 949 149,6			2 539 265,0			1 902 587,6		
Япон улс	7 113,2	0.5	123,0	15 088,5	0.8	212.1	27 589,0	1.1	182.8	4 564,0	0.2	16.5
Импорт	1 485 609,8			2 170 133,2			3 615 832,6			2 131 308,8		
Япон улс	97 628,5	6.6	141.7	140 217,7	6.5	143.6	238 855,9	6.6	170.3	97 002,1	4.6	40.6

Монгол Улсаас Япон Улс руу хийгдсэн гол экспортын бүтэц:

- ✓ хагас боловсруулсан ноолуур
- ✓ тэмээний ноос
- ✓ ноолууран эдлэл
- ✓ тэмээний ноосон хөнжил
- ✓ зэсийн баяжмал
- ✓ катодын зэс
- ✓ хүнсний бүтээгдэхүүнээс иодын давс
- ✓ адууны мах
- ✓ архи

Япон улсаас Монгол Улс руу хийгдсэн импортын бүтэц:

- ♣ цагаан будаа, ♣ пиво, архи дарс,
- ♣ шар буурцагны тос, ♣ тамхи,
- ♣ эрүүл мэндийн тоног төхөөрөмж,
- ♣ эмийн бүтээгдэхүүн ♣ саван
- ♣ хатуу чихэр будаг, ♣ лак
- ♣ гурилан бүтээгдэхүүн, ♣ шоколад,
- ♣ суудлын болон ачааны автомашин
- ♣ сэлбэг хэрэгсэл ♣ барилгын материал
- ♣ машин механизмын эд анги, төрөл бүрийн хөдөлгүүрүүд,
- ♣ цахилгаан бараа, ♣ цахилгаан үүсгүүр,
- ♣ харилцаа холбооны техник хэрэгсэл

Импортод суудлын автомашины хувийн жин хамгийн өндөр байна. Япон улс дэлхийд импортын хамгийн том зах зээлийн нэг мөн боловч нэвтрэхэд нэлээн төвөгтэй, туйлын нарийн зохион байгуулалттай импортын зохицуулалттай орон юм.

Импортын бүтээгдэхүүнд үүсэл гарал, чанараар нь нарийн тогтоосон стандарт, зөвшөөрлийн системийн дагуу хяналт тавьдаг. Иймээс японы зах зээлд шинээр нэвтрэхэд нилээд төвөгтэй, харьцангуй зардал ихтэй байдаг байна.

Монгол улс Японд олон нэр терлийн бараа экспортлож болох боловч хэд хэдэн хүчин зүйлийг тооцож үзэх хэрэгтэй болно. Үүнд:

- ✓ Зах зээлийн эрэлт, үнийн хэлбэлзлийн нөлөөнд хэт орохгүйн тулд экспортын барааны нэр төрлийг олшруулах
- ✓ Японы худалдан авагчид Монголыг экспортлогч, үйлдвэрлэгчийнх нь хувьд сайн мэдэхгүй учир чанарт сайн итгэхгүй байх талтай.
- ✓ Нэгэнт зах зээлд нэвтрэн орсон барааны чанарыг бууруулахгүй байх ёстой. Хэрэв барааны чанар буурвал экспортын нэр хүнд унах аюултай. Тухайлбал 1995 оноос Монгол Япон улсад адууны мах нийлүүлж байсан бол яваандаа чанар нь буурсан тул экспортыг зогсоосон билээ.
- ✓ Манай улс далайгаас алслагдсан учир экспортын барааны өртөг зардал өсч Японы зах зээлд өрсөлдөх чадваргүй болох талтай

Монгол хэрэглэгчдийн хувьд Япон улсын барааг худалдан авах эрэлт хэрэгцээ нь өсөх хандлагад нөлөөлж буй хэд хэдэн хүчин зүйлс байна. Үүнд:

- ✓ Японы гэр ахуйн болон электрон бараа нь чанар сайтай \Brand name\ -ийн бараа байгаатай шууд холбоотой.
- ✓ Японы дэлхийд нэр хүндтэй олон пүүс корпорациудын албан ёсны гэрээт борлуулагчид монголд ажиллаж борлуулалтыг нэмэгдүүлэх маркетингийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.
- ✓ Японы үйлдвэрлэл, худалдааны томоохон компани, нэгдлүүд болох Иточу, Сумито, Нишшёо, Ивай, Мирубени, Комацу, Тоёото, Сузуки, Мицубиши зэрэг Монголд өөрийн гэсэн төлөөлөгчийн газраа нээсэн нь хоёр орны худалдаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нэг түлхэц хүчин зүйл болж байна.
- ✓ Монгол хэрэглэгчид Япон барааг худалдан авах, хэрэглэх нь нэр хүндийн хэрэг гэж үздэг байна, Тухайлбал суудлын автомашин, электрон барааг бусад улсынхаас илүү ихээр худалдан авч байгаа нь судалгаагаар тодорхойлогдсон билээ.

2. Шууд хөрөнгө оруулалт

1990 оноос эхлэн: шууд хөрөнгө оруулалт хийгдэх эдийн засгийн орчин бүрэлдэн бий болсон юм.

1993 онд: Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсан

2001 онд: Монгол Японы Засгийн газар хооронд Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай хэлэлцээр

2003 онд: Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг

1990-2009 оны хооронд: 132 орчим сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт Япон улс - 4 дэх том хөрөнгө оруулагч орон юм.

Хөрөнгө оруулалтын бүтэц салбараар:

- ✓ Худалдаа нийтийн хоолны салбарт - 46.21 %
- ✓ Хөнгөн үйлдвэрийн салбарт - 21,41 %
- ✓ Мэдээлэл, харилцаа холбооны салбарт - 7.38%
- ✓ Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт - 7,35 %
- ✓ Банк, санхүүгийн үйл ажиллагааны салбарт - 5,44%
- ✓ Тээврийн салбарт - 2.92 %
- ✓ Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт - 2.19 %
- ✓ Мал аж ахуй гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт – 1.41 %



Японы хөрөнгө оруулалтын жишээг дурьдвал:

- ✓ Ноолуур боловсруулах, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт: Санширо, Т энд Ай, Говь ХК, Туяа, STM International
- ✓ Зочид буудал, ресторан үйлчилгээний салбарт: Palace hotel, Yokozunanet, Hasabe International, Sansar Bridge, Sapporo
- ✓ Барилга, барилгын засал чимэглэлийн салбарт: Суруга Mongol, Himon Construction
- ✓ Банк, санхүүгийн салбарт: КНААН Bank,
- ✓ Шингэрүүлсэн шатдаг хийн салбарт: Юнигаз
- ✓ Олон улсын тээвэр зуучийн салбарт: Erin International
- ✓ Эрчим хүчний тоног төхөөрөмжийн салбарт: Megapower

- ✓ Аялал жуулчлалын салбарт: Бридж группын Цэнхэр Жигүүр, Жаргал жигүүр болон Daisogen зэрэг компаниуд,
- ✓ Боловсорлын салбарт : Соёл эрдэм, Нахиа зэрэг компани,
- ✓ Худалдаа үйлчилгээний салбарт: Бридж групп, Таван богд компаниуд,
- ✓ Японы машин худалдаалах үйлчилгээний салбарт: Моннис автосервис, JM International компаниуд

Японы хөрөнгө оруулалттай Суруга Монгол нь Монгол улсад оруулсан гадаадын хамгийн том 10 хөрөнгө оруулалттай компаний тоонд орж байна.

Монгол-Японы хамтарсан Мобиком компани нь үүрэн телефон үйлчилгээний салбарт маш амжилттай ажиллаж буйг бид бүхэн мэдэх билээ. Мөн Японы хөрөнгө оруулалттай зарим компани компьютерийн программ хангамж, мөн үнэт цаасны зах зээлд ажиллаж байна.

Монгол улсын аялал жуулчлалын салбарт Японы жуулчдын хувь ихээхэн байдаг. Энэ нь цаашид өсөх хандлагатай байгаа бөгөөд жуулчлалыг хөгжүүлэхэд зам, тээвэр зочид буудлын дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд энэ нь биет хөрөнгө оруулалт ихээхэн шаарддаг салбар юм. Энэ салбар хүчтэй хөгжих ирээдүйтэй гадаадын хөрөнгө оруулалтыг татах ихээхэн боломжтой юм. Гэвч энэ салбарт Японоос хөрөнгө оруулалт ороход зарим саад бэрхшээл учирч байна. Үүнд:

- ✓ Нислэгийн тийз өндөр үнэтэй, онгоцны тоо цөөн, үйлчилгээ төдийлөн чанартай биш байна.
- ✓ Жуулчдыг хүлээн авдаг компаниудын маркетингийн иж бүрдэл зохистой тогтоогдож чадаагүй \ бүтээгдэхүүн, үйлчилгээ, зохион байгуулалт, хяналт \ байна.
- ✓ Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бодит саад бэрхшээл болж байгаа нэг зүйл бол Монгол улсад дэд бүтэц төдийлэн сайн хөгжөөгүй байгаа зэрэг саад бэрхшээлүүд бодитойгоор нөлөөлж байна.

3. Япон улсаас Монгол улсад олгож буй зээл тусламж

Япон улс Монгол улсад өрнөсөн ардчилал шинэчлэлийг дэмжиж, эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулахад төрөл бүрийн тусламжийг тасралтгүй үзүүлсээр байгаа юм. Монгол улсыг дэмжигч орнууд, олон улсын байгууллагуудаас 1990 оноос Монголд олгосон нийт зээлийн 23 хувийг Япон дангаараа олгосон байна.

1990 оноос хойш авч ашигласан зээл, тусламжийг манай улс шилжилтийн эхэн үе буюу 1990-1993 онд бараа, таваарын хомсдол, эрчим хүчний дутагдлыг арилгах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зэрэг цаг үеийн тулгамдсан зайлшгүй хэрэгцээнд зориулж байсан бол 1994-1995 онуудад дунд хугацааны төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, жижиг дунд үйлдвэрлэлүүдийг сэргээх, хөгжлийн судалгаа хийх зэрэгт зориулах болсон байна.

Эдийн засгийн байдал тогтворжиж, сэргэх хандлагатай болж эхэлсэнтэй холбогдуулж 1996 оноос хойш Япон улсын зээл тусламжийг хөгжлийн урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, авто болон төмөр зам, уул уурхай, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбар, улс орны ирээдүйн хөгжлийн тулгуур болох салбаруудад зарцуулах хандлагатай болж ирлээ.

Япон улсын засгийн газраас олгож буй зээл, тусламж нь манай орны бүхий л салбарыг хамарч Монгол улсын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа ба өнөөдөр Япон улсын тусламж хүртээгүй салбар аймаг, сум, хувь хүн бараг байхгүй байна.

Япон улсаас Монгол улсын төлбөрийн балансыг дэмжих зорилгоор нийт 9 удаа Төслийн бус тусламж үзүүлээд байгаа бөгөөд тодорхой салбаруудад хөгжлийн судалгаа хийж, Техник хамтын ажиллагааны шугамаар хэд хэдэн төсөл хэрэгжүүлж, JICA-ийн шугамаар олон хүн сургаж байна.

Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагааны тухай "Говь" комбинатыг барих тухай хэлэлцээрийг 1977 онд байгуулж, түүний хүрээнд 5 тэрбум иений (17 сая ам.доллар) буцалтгүй тусламж олгосноор Японы хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-д Монгол улс хамрагдах болсон.

Японы ХАЁТ-ын хамтын ажиллагаа 1990-ээд оноос идэвхижиж, Япон улс Монголд олгож буй гадаадын зээл тусламжийн гуравны нэг буюу дунджаар 45-50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 30-50 сая ам.долларын буцалтгүй тусламж, 10 гаруй сая ам.долларын техникийн хамтын ажиллагааны тусламж олгож байна.

1997 оны 3 дугаар сард болсон "Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны өндөр хэмжээний уулзалт"-ын үеэр хоёр талын харилцан тохиролцооны дагуу үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэх (эрчим хүч, тээвэр, холбоо) ,зах зээлийн эдийн засагт шилжихэд чиглэсэн оюуны тусламж, хүн сургалт, газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх, амьжиргааны үндсэн эрэлт хэрэгцээ (боловсрол, эрүүл мэнд, усан хангамж) гэсэн 4 үндсэн чиглэлээр Японы ХАЁТ-г авч ашиглаж ирэв.

Японы зээл тусламжаар "Говь" комбинат, Хархорины үр тарианы агуулах, Хобооны газрын станц, Замын Үүдийн бараа сэлгэн ачих байгууламж, Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийг барьж байгуулах, Дарханы мах комбинат, Улаанбаатарын сүүний үйлдвэр, Улаанбаатарын IV ДЦС; Шивээ-Овоо, Багануурын нүүрсний уурхай, сумдын дизель станцыг шинэчлэх, Налайхын асфальтан чулуун зам тавих, хүнсний бүтээгдэхүүгийн нэмэгдүүлэх, төмөр замын тээх нэвтрүүлэх чадварыг сайжруулах, хотын нийтийн тээврийг сайжруулах, Нэгдсэн 2-р эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг нийгэм эдийн засгийн салбарын олон төслүүд хэрэгжсэн билээ.

Монгол улсын шилжилтийн эдийн засгийн хүндрэлтэй байдлыг харгалзан үзэж, төлбөрийн балансыг сайжруулах төслийн бус буцалтгүй тусламжийг 9 удаа олгож, нийт 15 тэрбум 500 сая иений хөрөнгөөр бараа нийлүүлэлт хийсэн байна. "Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөр"-ийн хүрээнд тусламжийн тэргүүлэх салбараар

- ✓ Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог сайжруулах, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж
- ✓ Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж
- ✓ Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж
- ✓ Эдийн засгийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгоход үзүүлэх тусламж гэж тодорхойлсон.

Монгол улс Япон улсаас олгож буй зээл тусламжид дулдуйдан жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгож ажилгүй ядуу иргэдийг дэмжих, ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн техник технологийг сайжруулах зорилт тавин ажиллаж байгаа билээ.

Дүгнэлт

Монгол-Японы худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх талаар дараах санал дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол улсаас Япон улсад экспортлож байгаа барааны чанарыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тоог нэмэгдүүлэх зорилтыг Засгийн газрын бодлогоор зохистой дэмжих, \экспортын таваар үйлдвэрлэгчдийг татвараас хөнгөлөх, техник технологийг шинэчлэх боломжийг худалдааны төрөл бүрийн бодлогоор дэмжих\
2. Япон улсаас Монгол улсад оруулах шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, \шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг улам таатай болгох, хөрөнгө оруулалтыг урамшуулах үүднээс гаалийн татварын хөнгөлөлтийг зохистой тогтоох\
3. Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг улам өргөтгөн хөгжүүлэхэд дэлхийн ба бүс нутгийн интеграцын үр өгөөжийг ашиглах явдал чухал ач холбогдолтой болж байна.

Манай хоёр улс Зүүн хойд Ази, Ази Номхон далайн бүсэд хамаарагддаг. Иймд Монгол улс бүс нутгийн интеграцид багтвал тогтвортой бөгөөд эрчимтэй хөгжих боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд Чөлөөт худалдааны хэлэлцээр \цаашид ЧХХ, FTA-free trade agreement\ байгуулах ажиллагаа эрчимтэй явагдаж байна. ЧХХ-г хоёр орны хооронд, бүс нутгийн хооронд байгуулж болдог. Иймээс Монгол улс, Япон улсын хооронд ЧХХ байгуулах асуудлыг ярилцан судалгааны болон бэлтгэл ажлыг эхлүүлэх боломжтой гэж үзэж байна.

4. Япон улсаас Монгол улсад хөрөнгө оруулалт хийх боломж бүхий аялал жуулчлалын салбарт бодитой оршиж байгаа саад бэрхшээлийг даван туулахад хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг чиглүүлэх

5. Япон улсаас олгож буй зээл тусламжийг хамгийн үр ашигтай ашиглах арга замыг төлөвлөн хэрэгжүүлэхэд Монголын засгийн газар дорвитой арга хэмжээг авах
6. Япон Монголын худалдаа харилцаа, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлыг хэрэгжүүлэх урт ба дунд хугацааны үндсэн чиглэл, төлөвлөгөө боловсруулах

Ном зүй.

Архивын эх сурвалж, хэвлэгдсэн баримтын материал

1. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ.,1994
2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.,1994
3. Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр. УБ.,2009
4. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ.,2008
5. Монгол улсын статистикийн бюллетень. УБ.,2007,2008,2009
6. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн мэдээлэл.\ГХОГХА\.\УБ.,2008

Судалгааны бүтээл

1. Баатар Ц.Глобальчлалын эриний Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа. УБ.,2007
2. Батбаяр Ц.Монгол ба их гүрнүүд ХХ зууны эхэн хагаст. УБ.,2006
3. Төмөрчулуун Г.Даяар ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа УБ.,2009

Тогтмол хэвлэл

1. “Олон улс судлал” ШУА, ОУСХ.УБ, 2001-2009
2. “Гадаад харилцаа”ГХЯ-ны мэдээллийн товхимол. 1996-2009 он УБ.,